



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 04 сарын 13 өдөр

Дугаар 15

Шарга

Шагналд дэмжих тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8, Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийн хавсралт "Монгол улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам"-ын 8 дугаар заалтыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

1. Тус сумын 6-р багийн иргэн, өндөр настан Сэрээтэрийн Бүдийг эх орныхоо тусгаар тогтнолын төлөө байгуулсан гавъяаг нь үнэлэн "Цэргийн гавьяаны одон"-оор, өндөр настан Гомбосүрэнгийн Жадамбыг "Цэргийн гавьяаны улаан тугийн одон"-оор тус тус шагнуулах тухай тодорхойлолтыг дэмжин аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр дэмжүүлэх хүсэлтийг аймгийн Засаг дарга /А.Эрдэнэбаатар/-д уламжилсугай.

2. Монгол улсын "Цэргийн гавьяаны улаан тугийн одон"-д тодорхойлсон Гомбосүрэнгийн Жадамба, "Цэргийн гавьяаны одон"-д тодорхойлсон Сэрээтэрийн Бүд нарын анкет, холбогдох материалыг хавсарган Аймгийн Төрийн захиргаа удирдлагын хэлтэст материалыг хүргүүлж дэмжүүлэн ажиллахыг сумын Засаг дарга Д.Түмэнбаярт даалгасугай.

ДАРГА

Ч.АЗБАЯР

D:2015/Togtool 04.13/.docx

00000222